



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 409 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсын 2024 оны төсвийн хөрөнгөөр Төрийн худалдан авах ажиллагааны газраас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт"-д энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан төсөл, арга хэмжээг, 2 дугаар хавсралтаар баталсан "Монгол Улсын 2024 оны төсвийн хөрөнгөөр аймаг, нийслэлд эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт"-д энэ тогтоолын 2 дугаар хавсралтад заасан төсөл, арга хэмжээг, 3 дугаар хавсралтаар баталсан "Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалт"-д энэ тогтоолын 3 дугаар хавсралтад заасан төсөл арга хэмжээг тус тус нэмсүгэй.

2. Мөн тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсын 2024 оны төсвийн хөрөнгөөр Төрийн худалдан авах ажиллагааны газраас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт"-аас энэ тогтоолын 4 дүгээр хавсралтад заасан төсөл, арга хэмжээг, 2 дугаар хавсралтаар баталсан "Монгол Улсын 2024 оны төсвийн хөрөнгөөр аймаг, нийслэлд эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт"-аас энэ тогтоолын 5 дугаар хавсралтад заасан төсөл, арга хэмжээг тус тус хассугай.

3. Энэ тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт, Төрийн худалдан авах ажиллагааны газар (Ц.Батзул)-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

С.АМАРСАЙХАН

Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 26 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ 409 ДҮГЭЭР ТОГТООЛЫН 2 ДУГААР ХАВСРАЛТААС ХАСАХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

/сая.төгрөгөөр/

| Хуулийн дугаар | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Төслийн код | Эхлэх | Дуусах | Төсөвт өртөг | Санхүүжих дүн |
|----------------|--|--------------|-------|--------|--------------|---------------|
| V | МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА | | | | | |
| V.3.5 | Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж /Төв/ (-) | УТ2401000280 | 2024 | 2024 | 150.0 | 150.0 |
| VI | БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД | | | | | |
| VI.3.4 | Цаг уурын албаны тоног төхөөрөмж /Төв/ (-) | УТ2401300904 | 2024 | 2024 | 105.0 | 105.0 |
| XI | ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД | | | | | |
| XI.3.3.1 | Тусгай хэрэгцээт иргэдийн тоног төхөөрөмж /Төв/ (-) | УТ2403901092 | 2024 | 2024 | 150.0 | 150.0 |
| XI.5.1.12 | Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар болон Гэр бүл, хүүхэд, залуучуудын газарт барилга худалдаж авах /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ | УТ2403901086 | 2024 | 2025 | 8,232.6 | 3,500.0 |
| XI.5.3.3 | Ахмадын хөгжлийн төвийн тоног төхөөрөмж /Төв/ (-) | УТ2403901093 | 2024 | 2024 | 100.0 | 100.0 |
| XII | БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД | | | | | |
| XII.1.102 | Сумын төвийн цэвэр, бохир ус дулааны шугам сүлжээ /Ховд, Үенч сум/ | УТ2402901669 | 2024 | 2025 | 3,000.0 | 1,500.0 |
| XIII | БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД | | | | | |
| XIII.1.3.18 | Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Төв/ (-) | УТ2401502604 | 2024 | 2024 | 215.0 | 215.0 |
| XIII.1.3.19 | Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Төв/ (-) | УТ2401502570 | 2024 | 2024 | 1,500.0 | 1,500.0 |
| XIV | СОЁЛЫН САЙД | | | | | |
| XIV.3.6 | Нийтийн номын сангийн тоног төхөөрөмж /Төв/ (-) | УТ2403401129 | 2024 | 2024 | 100.0 | 100.0 |